

Ажиллах эх:

Байдалд зохист намар цаг, сэтгэлд зохист яруу газар, Бэлэндалай гэдэг зөөлөн говь нутагт нэгэн хэсэг олон адуу сүрэглэн явахад адуу хэдийгээр алхлавч зөөлөн хуурай хөрс нь адууны хөлд гишгэгдэж, улбар тоос бужигнан, улмаар аясын салхинд туугдсаар цэлмэг агаарт замхарна.

Ардаг тарган адуу нь алс талдаа бэлчихэд адуучин ядуу ард нь гэрийн зүг хүсэв. Эдэлсэн эзэн гэртээ дурлаж, эдлэгдсэн морь нь ижилдээ дурлаж, унасан морины толгойг хазаарын хүчээр эргүүлэвч бүхэл бие нь адууны зүг явж, уурга ташуур хөшилдөөд, унасан морь тэмцэлдээд, тал дээр ганц бие, адуун дотор ааш догширч, морины гуянд бүдүүн ташуур тас няс хийтэл тушааж, адууны дундаас халиун морийг унасан, урт уурга чирсэн нэг гавшгай хүн гарч өмнө зүг чиглан давхисаар наг баялаг айлын гадаа буужээ. Энэ хүн бол гучаад настай, махлаг хөх царайтай, толгойд хир болсон хөх цууямбуу зангиджээ. Нэр Долингор гэдэг.

Нэгдүгээр ажил. Эх задлал (6 оноо)

1. Хэрэг явдлын орон цагийн санааг давтан тодосгосон өгүүлбэрийг олж бич. (1 оноо)
2. Харьцуулсан өгүүлбэрийг хос хосоор нь товчлон ялгаж бич. (3 оноо)
3. Долингорыг хэдэн янзаар нэрлэснийг олж бичнэ үү. (2 оноо)

Хоёрдугаар ажил. Өгүүлбэр зүй (5 оноо)

Ажиллах өгүүлбэр: Байдалд зохист намар цаг, сэтгэлд зохист яруу газар, Бэлэндалай гэдэг зөөлөн говь нутагт нэгэн хэсэг олон адуу сүрэглэн явахад адуу хэдийгээр алхлавч зөөлөн хуурай хөрс нь адууны хөлд гишгэгдэж, улбар тоос бужигнан, улмаар аясын салхинд туугдсаар цэлмэг агаарт замхарна.

1. Өгүүлэгдэхүүн өгүүлэхүүний холбоо харьцаатай чөлөөт холбоо үгсийг ялгаж бич. (2 оноо)
2. "сүрэглэн явах" гэсэн төгс бус өгүүлэхүүн өмнөө ямар үгсийг захирч, хойшоо ямар үгстэй холбогдсон байна вэ? (1 оноо)
3. "хөрс нь адууны хөлд гишгэгдэнэ" гэснийг гурван гишүүнт цем өгүүлбэр болгон хувиргаж бич (1 оноо)
4. "Байдалд зохист намар цаг, сэтгэлд зохист яруу газар, Бэлэндалай гэдэг зөөлөн говь нутагт нэгэн хэсэг олон адуу сүрэглэн явна." гэсэн өгүүлбэрээс үйлийн бүлгийг ялгаж бичнэ үү. (1 оноо)

Гуравдугаар ажил. Үгийн сан, утга зүй (4 оноо)

1. "алхлавч, гишгэгдэх" гэдэг хоёр үгийн утга санааны зохирлыг тодорхойл. (1 оноо)

2. "Морины толгойг эзний хүчээр биш, хазаарын хүчээр эргүүлнэ" гэсний учрыг бич. (1 оноо)
3. Тодотгогч, тодотгуулагчийн байрыг оновчлох нэг жишээг эхээс олж тэмдэглэ. (1 оноо)
4. "тэмцэлдээд" гэдэг үйлийн учир зүйн үйлдэгчдийг тоочно уу. (1 оноо)

Дөрөвдүгээр ажил. Хэл зүйн үг, бүтээвэр (4 оноо)

1. "бужигнан" гэдэг үгийг бүтээврээр задалж, бүтээвэр тус бүрийг нэрлэж бич. (2 оноо)
2. "эргүүлэвч, туугдсаар" гэдэг үйл үгийн бутцэд орсон "-вч,- саар" нөхцөлүүд ямар үүрэгтэй вэ? Энэ хоёр нөхцөлийн нэрийг бич. (1 оноо)
3. "тал дээр, зохист намар, тоос бужигнан" гэдэг холбоо үгсэд орсон "тал, зохист, тоос" гэсэн үгс дараах үгтэйгээ хэл зүйн ямар хэлбэрээр холбогдсоныг тайлбарла. (1 оноо)

Тавдугаар ажил. Зохион бичлэг (5 оноо)

"Ирээдүй" сэдвээр эргэцүүлмж зохион бич. (Үгийн тоо 100-120)

Зургаадугаар ажил. Уран зохиол (6 оноо)

- а. Д. Нацагдоржийн "Дөрвөн цаг" шүлэгт үндэсний мэдрэхүйг /онцлог/ тусган үзүүлсэн нь (4 оноо)
- б. Төлөөлөл гэсэн дүрслэх ур маяг (хэрэглүүр)-ийг тодорхойлж, хоёроос доошгүй төрлийг жишээгээр тайлбарла. (2 оноо)

Долоодугаар ажил. Монгол бичиг (10 оноо)

Цээжээр бичнэ үү

МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН УЛСЫН ОЛИМПИАДЫН ГУРВЫН ДАВААНЫ СЭДЭВ БАГШ

Нийт оноо 50

Ажиллах эх:

Болд, хоосон амаа ангайж, амьсгал давхцаж, ийш тийш харж цүлхгэнэн зогсоно. Долингор ганцаар нүүх ажлыг захирч хөдөлгөв. Баян Болдын нүүж явахад хаяа сахисан ядуу айлууд Дэжидийн хараалыг их гэгчээр амсаж, үнээ шүдлэн хөллөөд нүүв. Долингор Болдын ажлыг оролдох тул гэрээ нүүлгэх завгүй болж, гаднаа хэдэн үхэр уяж орхив. Мядаг ганцаараа нүүх ажлыг засаж оролдох гэвч, бие хүндэрч ажил хийх аргагүй ядарчээ. Хүүхдийг төрөхөд эх барьж авах гэсэн Дамдингийн ээж майжиг жайжиг гэж оролдсоор хэдийн муу гэрээ ачаалсан боловч Мятагийн ганцаар хоцроход хүрснийг мэдэж харгалзан хүлээв. Хоёр ядуу бүсгүй алгын чинээ балчир хүүхэдтэй гурвуулан айхын ихээр айж, зовохын ихээр зовж, баян айлын хар нутгийг сахив. Цагаан гэгээ тасрахын хэрд Мятаг нярайлахаар өвдөж, эмгэн түших араг, суух дэвсгэр зэргийг

дөнгөж бэлтгээд Мядагийг суулгаж гарыг түшихэд нэг үе хүчтэй өвдөөд хүүхэд нь гарлаа.

Эмгэн ухаан зүггүй сандарч, учир зүггүй бөгтгөнөж гүйхээс өөр бүтээх юмгүй, бас ч нүүх гэж гэрийн оосор бүчийг тайчиж, хаяа хатавчийг онгойлгосон тул шөнийн хүйтэн салхи гэрийн дотуур сэржигнэж бас эмгэн гал түлэхийг мартсан тул хэдийн гал унтарчээ. Эмгэн сая сэхээ орж, дэнгийн гэрлийг сүүмэлзүүлж, нярай төрсөн үрийг хонины арьсанд боож, Мядагийн биеийг хучиж суулгаад галыг ноцоож, нутаг дээр үлдсэн аргал хорголыг хормой хормойгоор авчирч, утаа май манаруулан түлж, шөл хийж өгөв. Харин золоор хэдэн хоногийн урьд Долингор нэг муу эм хонио нядалж өгсөн ажээ.

Нэгдүгээр ажил. Эх задлал (7 оноо)

1. Найруулгын хэв шинжийг тодорхойлно уу. (1 оноо)
2. Цогцолбоын сэдлийг тайлбарлана уу. (1 оноо)
3. Цогцолборын нарийвчилбарыг жишээгээр тайлбарлана уу. (3 оноо)
4. Цогцолборын дүрслэх ур маягийн жишээг олж бичнэ үү. (2 оноо)

Хоёрдугаар ажил. Өгүүлбэр (7 оноо)

Ажиллах өгүүлбэр:

Хүүхдийг төрөхөд эх барьж авах гэсэн Дамдингийн ээж майжиг жайжиг гэж оролдсоор хэдийн муу гэрээ ачаалсан боловч Мядагийн ганцаар хоцроход хүрснийг мэдэж харгалзан хүлээв. ...Харин золоор хэдэн хоногийн урьд Долингор нэг муу эм хонио нядалж өгсөн ажээ.”

1. Өгүүлбэрээс баймжит ба баймжит бус, шалтгаант ба шалтгаант бус харьцааг илтгэсэн жишээ тус бүр нэгийг бич. (2 оноо)
2. Өгүүлбэрийн гүн бүтцийг үйлдэгчийн үүднээс тодорхойл. (3 оноо)
3. “төрөхөд” гэдэг үг нь өгүүлбэр зүйн ямар холбоо харьцаанд байгааг тайлбарла. (1 оноо)
4. “золоор” гэдэг үгийн баймж утгыг тодорхойл. (1 оноо)

Гуравдугаар ажил. Үгийн сан, утга зүй (6 оноо)

1. “уул завсарлах цаг” гэдэгтэй утга эсрэгцэх хэллэгийг үг уг эхийн дотор орлон зохирох газрыг олж тэмдэглэнэ үү (1 оноо)
2. “... хоосон амаа ангайж” гэдгийн “хоосон “ нь “баян”-таёй утгаараа эсрэгцэх үү. (1 оноо)
3. “гал түл”, “галыг ноцоо” гэх мэтээр заахын тийн ялгалаар ил далд хэлбэржүүлсний учрыг тайлбарла. (1 оноо)
4. “шүдлэн хөллөөд нүүв”, “шүдлэн гурав хөллөөд явав-” гэхэд “хөллө” нь утгын ялгаатай эсэх (1 оноо)
5. “хар нутаг сахих-“ хэллэгийн саармагжсан үнэлэмж давхцах тохиолдлыг тайлбарла. (1 оноо)
6. “хаяа сахих”, “хар нутаг сахих-“ гэхэд сөрөг үнэлэмжтэй хэрнээ “дүрэм сахих” гэхэд үнэлэмж маармагшдгийн учрыг тодорхойл (1 оноо)

Дөрөвдүгээр ажил. Хэл зүйн үг, бүтээвэр (6 оноо)

1. Дараах үйл үгсийн дотроос алдаатай бичсэн үгийг олж зөв болгон бичээд учрыг нь тайлбарла. (2 оноо)
дэнжигнэ-, санжгана-, бөнжгөнө-, хүржгэнэ-, торжигно-, шаржигна-
2. Дараах өгүүлбэрт орсон “хугачихыг, үнэмшчихийг, үзчихээд” гэсэг гурван үгийг бүтээврээр задалж, бүтээвэр тус бүрийг тайлбарла. (2 оноо)
3. Дараах өгүүлбэрт нэрийн тийн ялгалын нөхцөлтэй үг хэд байна вэ? (2 оноо)
Баян Болдын нүүж явахад хаяа сахисан ядуу айлууд Дэжидийн хараалыг их гэгчээр амсаж, үнээ шүдлэн хөллөөд нүүв.

Тавдугаар ажил. Зохион бичлэг (5 оноо)

“Ус” сэдвээр эргэцүүлэмж зохион бич. (Үгийн тоо 120-150)

Зургаадугаар ажил. Уран зохиол (8 оноо)

1. *“Төр, хувцсаа тайчин хаяж
Түмний дундуур шалдан явдаггүй юм.
Төр, ёс ямбаны хувцсан дотроо
Төмөр илд, цагаан сүү хоёрыг нууж явдаг юм...”*
Арчуг хааны энэ үгийн утга, бэлгэдэл, уран сайхныг тайлбарла. (2 оноо)
2. *“... Эцгийгээ үхэхээр чи
Эрхт төрийн ёс тийм гэсэн...”*
Ачирын энэ үгийн утгыг “Эдипийн цогцолбор” (Зигмунд Фрейд), “эхнэр” гэдэг үгийн гарал (Б.Ринчен)-тай холбон тайлбарла. (1 оноо)
3. *“...Хаан цусанд од унаж
Харгуйгаа соьж урсав
Тэр нь намайг дайрч урсав
Тэнгэр намайг татаж босгов...”*
Эгэрэг түшмэлийн энэ үгийн далд утга санааг тайлбарла. (1 оноо)
4. *“...Хаан хэрмэн дотор
Хамаг амьтны алган дээр
Дээд доод хоёр нүхээрээ бордуулсан
Дэндүү тэнэг нялцгай эм минь ...”
Умдаг чинь чамайг
Хатан болгосон болохоос
Ухаан чинь чамайг
Хатан болгоогүй ...”*
Эгэрэг түшмэлийн энэ үгийн утгыг тайлбарла. (2 оноо)
5. *“...Хүннү төрийн тамгыг барих
Хүнгүй болохоор нь
Хоёр сүүн уулын цаана
Хорин улаан горхины уулзах газар булчихсан.
Есөн үеэр сахилж
Ерхөг өвсийг нь ч битгий хөдөлгөө гэж*

*Нэгэн биений эрхтэн шиг итгэлт отогтоо
Захиад онголчихсон ...
Чи тамгатай болж болно
Ядуу боолын тойгны
Ясаар нь тамга сийлж
Цусанд нь дүрж тамгална биз ...”*

Арчуг хааны энэ үгийн утга, бэлгэдлийг тайлбарла. (2 оноо)

Долоодугаар ажил. Монгол бичиг (10 оноо)

1. Цээжээр бичнэ үү.

**2019 ОНЫ МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН УЛСЫН ОЛИМПИАДЫН СЭДЭВ СУРАГЧ
Нийт оноо 35**

Ажиллах эх:

Чөдөр

Аваараа би чөдөр зангидахыг заалгана. Торго шиг зөөлөрсөн эр сур гарынх нь аясаар ид шидийг олном за. Хоёр алгаа үлээн байж эр сурыг томохуй дор чөдрийн сум бий болно.

Аав хэлнэ. “Эрч нь сайн байх тусам улам бөх болно”. Дараа нь аав хааг нь гаргана. Чөдрийн хаа гэж урд талынх нь хоёр салааг хэлж байна. Төөлнө, сөөлнө. Дөрвөн хуруу тавьж байн байн хэмжинэ.

Аав хэлнэ. Хэмжээ дамжаа нарийн байх учиртай. Эс тэгвээс морь зовоочихно.

Сураа давхарлаж шилбийг хийнэ. Торго шиг эр сурнаас хамгийн зөөлнийг нь сонгоно. Дараа нь гогцоогоо гаргана. Тэгээд хумсыг нь хийнэ дээ. Зөөлхөн хуш мод бүр ч их тохиромжтой. Чөдрийн алга ийнхүү бий болно.

Аав хэлнэ. “Морины сагаг зулбарахгүй боллоо. Үс нь ч гэмтээгүй хөлтэй морь үлийд бүдрээд унадаггүй юм.”

Чөдөр зангидахуй дор ухаан улам төвлөрч гарт бяд суунам. Би чөдөр зангиад дуртай билээ. Аав минь “Хол ойрын хүнийг л унаанаас нь салгав даа” гэдэг сэн.

Таны үг одоо ч чиэхэнд сонсогдоном. Би хүүдээ энэ үгийг улбаалан захиана. Хүн бүр өөр өөрийн хүлэгтэй билээ.

Дан. Нямаа

ГҮЙЦЭТГЭХ ДААЛГАВАР:

Нэгдүгээр ажил. Эхийн даалгавар (5 оноо)

1. Хөндлөнгийн өгүүлбэрүүдийн санааг харьцуулан бүлэглэж, дугаарлаарай. /3 оноо/
2. Өгүүлбэр болоод цогцолборуудыг ямар нөхцөлөөр ижилсүүлэн холбосон бэ? /1 оноо/
3. Үүсмэл тэмдгийн нэрээр өгүүлбэр төгсгөсөн баймжит санаа бүхий үгсийг түүж бич. /1 оноо/

Хоёрдугаар ажил. Өгүүлбэр (4 оноо)

1. “Чөдөр зангидахуй дор ухаан улам төвлөрч гарт бяд суунам.” гэсэн өгүүлбэрт “зангидахуй дор” гэсэн үг өгүүлбэр зүйн ямар холбоо, харьцаанд байгааг тайлбарла. /1 оноо/
2. “Аваараа би чөдөр зангидахыг заалгана.” өгүүлбэрийг өөрөө үйлдэх хэвд хувиргаж найруул. /1 оноо/
3. Дээрх өгүүлбэрээс цөм өгүүлбэрүүд үүсгэ. /1 оноо/
4. Аав хэлнэ. “Эрч нь сайн байх тусам улам бөх болно”. гэсэн өгүүлбэрүүд яаж холбогдсоныг тайлбарла. /1 оноо/

Гуравдугаар ажил. Үгийн сан, утга зүй (4 оноо)

1. Монгол сэтгэлгээний хэмжээсийн илэрхийллийг тодорхойлж, эшилнэ үү. /2оноо/
2. Дээрх эхээс “зөөлрөх” гэх санааг олж нэрлэ. /1оноо/
3. Хүнийг унаанаас салгах нь чөдөртэй ямар холбоотойг тайлбарла. /1 оноо/

Дөрөвдүгээр ажил. Бүтээвэр (4 оноо)

1. “Чөдөр зангидахуй дор ухаан улам төвлөрч гарт бяд суунам.” гэсэн өгүүлбэрт орсон тийн ялгалын нөхцөлтэй бүх үгийг олж бичээд ямар ямар тийн ялгалд байгааг нэрлэж бич. /2 оноо/
2. Дээрх эхэд байгаа “хааг нь, унаанаас нь, зөөлнийг нь” гэсэн үг тус бүрд орсон “- нь” нөхцөл тухайн зүйлийг хэнд, юунд хамаатуулж байгааг нь бичнэ үү./2 оноо/

Тавдугаар ажил. Зөв бичх зүй (3 оноо)

1. Дараах үгсийн дотроос дараалсан гурван гийгүүлэгчийн дүрмээр бичигдсэн үгсийг олж бичнэ үү. /1 оноо/

заалгана
сонгоно

сөөмлөнө
сонсогдоном

хэмжинэ
гаргана

2. “захина, хэмжинэ” гэсэн хоёр үгийн “-на, -нэ” нөхцөлийн өмнөх “и”-тэй холбогдох зөв бичих дүрмийг тайлбарлана уу. /2 оноо/

Зургаадугаар ажил. Зохион бичлэг (5 оноо)

1. Сэдэв “Мөнгө” Үгийн тоо 110-120

Долоодугаар ажил. Уран зохиол (5 оноо)

... Их мөрний хөвөөнд үнэт эрдэнэ гээчхээд эрж яваа юм шиг урагш хойш тонголзон холхих нэгэн хүний хэлбэр төрхийг алсаас харахад нар шингэх үеийн модны сүүдэр шиг тахир агаад нэн өндөр.

... Энэ ханхар цээжийг одоо яг наран сөрөг харуулаад сайтар ажиглавал уушги зүрх нь арьсаа нэвт харагадаж мэдэхээр агаад аягүй бол тэр том цээжинд ганц зүрх ... тээгэхдээ аварга том ганцхан, зүрх л энэ үерийн ус шиг булгилж байгаа юм бил үү, хэн мэдэх билээ.

1. Энд ямар хэний, ямар нэртэй зохиолоос эш татсан байна вэ? /1 оноо/
2. Энэ зохиолын сэдвийг тодорхойлж, аль нэг дүрийг задлан тайлбарла. /2 оноо/
3. Эш татсан өгүүлбэрүүдэд дүрслэх хэрэглүүлүүдийг ямар үүргээр хэрэглэсэн байна вэ? /2 оноо/

Наймдугаар ажил. Монгол бичиг (5 оноо)

2. Эхийг цээжээр бичнэ үү. /5 оноо/

**МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН УЛСЫН ОЛИМПИАДЫН СЭДЭВ
БАГШ**

Нийт оноо 40

Ажиллах эх:

Миний эх орон- миний тоонот

(хэсэглэн авав)

Дорнодын тал минь! Монгол хүний суу залиг бадруулсан баян тансаг, хотол төгөлдөр тал минь! Гадаад их далайн давлагаа мэт үелзэнхэн тогтсон ухаа гүвээнүүдийг давж, Хэрлэн мөрний холч урсгалыг дагаж, хэчнээн ч явав даа. Талдаа очиход сэтгэл найман сарын нарлаг өдөр шиг дэлгэр тэнүүн болно. Ганга нуурын ганган улаан бургас ганхаж байхыг үзсэн цаг амьдралын их олз мэт санагдан Тоорой бандийн домогт Шилийн богд, талын дунд асарлан цэнхэрлэхүйд монгол хүн оршин амьдарсан цагаас энэ гэрэлт дуулим тал минь хэчнээн юм үзээ болоо гэх зэрэг олон юм бодогдсон сон. Өнгөрсөн дайны талбар, монгол хөвгүүдийн цус шингэсэн Халх голын дэнж талд алимын мод цэцэглэн хэдэн сая дүнчүүр цагаан эрвээхэй газарт буусан юм шиг эх орон – тал нутгаа харийн дайснаас өмөөрөн тэмцэж амь алдагсдын гэгээн дурсгалыг тийнхүү таван сарын цагаан эрвээхэй – цэцгээр мялаасан юм шиг байхыг би үзсэн. Хэрлэнгийн усаар ундаалсан халхын удамт хурдан хүлгүүдийн тоосон дундаас түмний эх цойлон гарч, унасан хүүхдүүдийн цовоолог дуун хангинахад учиргүй уяхандаа ч биш сэтгэл жигтэй догдолсондоо нулимсаа сэмхэн арчиж явснаа хүртэл тэр болгон тохиолдохгүй явдал шиг санах юм. Талдаа миний тоонот байлаа.

С.Эрдэнэ

ГҮЙЦЭТГЭХ ДААЛГАВАР:

Нэгдүгээр ажил. Эхийн даалгавар (6 оноо)

4. Эхийн найруулга нь аль төрөл зүйлийн ямар жанрын эх болохыг тодорхойлно уу.
/1 оноо/
5. Дээрх эхтэй нь төстэй ямар ямар жанр байдаг вэ? /2 оноо/
6. Эхийн жанрын шинжийг тоочин дурдана уу. /3 оноо/

Хоёрдугаар ажил. Өгүүлбэр (5 оноо)

Ажиллах өгүүлбэр: Өнгөрсөн дайны талбар, монгол хөвгүүдийн цус шингэсэн Халх голын дэнж талд алимын мод цэцэглэн хэдэн сая дүнчүүр цагаан эрвээхэй газарт

буусан юм шиг эх орон – тал нутгаа харийн дайснаас өмөөрөн тэмцэж амь алдагсдын гэгээн дурсгалыг тийнхүү таван сарын цагаан эрвээхэй – цэцгээр мялаасан юм шиг байхыг би үзсэн.

5. Зүйрлэсэн өгүүлбэрүүд ямар үгтэй холбогдсоныг тайлбарла. /2 оноо/
6. “Тийнхүү” гэдэг үг ямар утга, үүрэгтэй байна вэ? /1 оноо/
7. Орны байц гишүүдийг олж, утгын ямар харьцаатай байгааг мэдээллийн үүднээс тайлбарла. / /1 оноо/
8. “Эх орон - тал нутаг” гэдгийн “тал нутаг” нь өмнөх үгтэйгээ ямар гишүүний харьцаатай байна вэ? /1 оноо/

Гуравдугаар ажил. Үгийн сан, утга зүй (5 оноо)

4. “гүвээнүүд”-ийг “толгод”-оор соливол утга хэрхэн өөрчлөгдөх вэ?
/1 оноо/
5. Хэрлэн мөрнийг “холч урсгалтай” гэсний учир /1 оноо/
6. “сэмхэн” гэдэг үг үйлийн арга заасан гэвэл ямар уялдмал утгатай холбож үзэх вэ? .
/1 оноо/
7. Хэрлэнгийн усаар ундаалснаас хурдан болсон гэх санаа байна гэвэл далдарсан утгыг хэлнэ үү. /1 оноо/
8. Хүний цус шингэсэн хөрснөөс хүний идэх жимс ургуулсныг хийсвэр сэтгэлгээний үүднээс тайлбарла. /1 оноо/

Дөрөвдүгээр ажил. Бүтээвэр, үгийн гарал (5 оноо)

3. “Энэ” гэдэг үгийн Э- язгуурын гурван хувилбарыг олж, тус бүрд нэг нэг жишээ бичнэ үү. /2 оноо/
4. “Хэчнээн” гэдэг үгийн түүхэн гарлыг тайлбарла. /1 оноо/
5. “алдагсдын” гэсэн үгийг бүтээврээр задалж, тус бүрийг нэрлэ. /2 оноо/

Тавдугаар ажил. Авиа зүй, зөв бичх зүй (3 оноо)

3. ганхаж- “н” авианы шинжүүдийг тодорхойлно уу. /2 оноо/
4. хангинаахад- онцолсон балархай эгшгийн үүргийг тодорхойлно уу. /1 оноо/

Зургаадугаар ажил. Зохион бичлэг (5 оноо)

2. Сэдэв “Өөрийгөө сонсохуй” Үгийн тоо 130-150

Долоодугаар ажил. Уран зохиол (6 оноо)

1. Д.Нацагдоржийн “Дөрвөн цаг” шүлгийн төлөвлөгөөг уншиж сийрүүлнэ үү. /1 оноо/
2. “Дөрвөн цаг” шүлэгт үндэсний мэдрэхүй, түүхэн ухамсар (хүмүүжил)-ийг хэрхэн үзүүлсэн бэ? /2 оноо/
3. Зохиолын зөрсөн утга гэж юу вэ? /1 оноо/
4. Д.Данзанравжаагийн “Ийиг ичиг” шүлгийн зөрсөн утгыг тайлбарла. /2 оноо/

Наймдугаар ажил. Монгол бичиг (5 оноо)

3. Эхийг цээжээр бичнэ үү. /5 оноо/

2023 ОНЫ МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН УЛСЫН ОЛИМПИАДЫН СЭДЭВ

(Сурагчид)

Нийт оноо 35

Ажиллах эх:

... Бээжинг идэх гэж долоохон зууны газар туулаад ирснийг миний их цэрэг даран няцаасан нь, гурван түмэн ойрад цэрэг ихэд хохирч, “Галдан их говийн зүг ухаангүй дутаав” гэж манай цэргийн жанжин айлтгаснаас хойш даруй таван жил болж, сая дахин Цэцэн хан аймгийн нутаг хүртэл байлдан орж, их олз омогтой эгжээ. Энэ жил бас л Галданы цэрэг Цэцэн ханы аймгийг идэж буй тул, хоёр замын их цэрэг хөдөлгөн, нэгэн замын цэргийг биеэр удирдан явах болсныг өнөөдөр яамлан мэдэгдлээ. Хэд хоногоос өдрийн сайныг үзэж аялан мордоно гэж бодоод, хэдэн сар эзгүй болох гэж байгаа бичгийнхээ танхимыг харав.

Туурга дагуу агар зандан ташингатад өрөөстэй бичмэл дармал, торгон хавтастай, хөх шар дугуйтай ном судар дунд арьсан хавтастай өөр янзын хэд хэдэн дэвтэр онц ялгаран харагдаж байгаа нь есүстний латин ном, баруун далайн улс орны газар зүйн зурагт дэвтэр тоо зүйн бичиг- цөм есүстний бэлэглэсэн ном бөгөөд хоёр буландаа тэнгэрийн дүрэмт сав; суман модон сийлмэл гурван луун дээр тогтоосон, одон орны байдлыг есүстэн багштайгаа үздэг хэрэгсэл. Бас нэг буланд газрын дүрэмт сав- голоороо дэлэм хэмжээний бөмбөрцөг түүнээ мөн есүстэн багшийн гараар Дайчин улсын газрын зургийг зурж, шинэ газар эзэлснийг улаанаар зурайтал тэмдэглэсэн нь тодорхой харагдаж байв.

(Б.Ринчен)

Нэгдүгээр ажил. Эх (6 оноо)

1. Дээрх 5 төгс өгүүлбэр хэдэн цогцолбор болсон бэ? Цогцолбор бүрийн төгс өгүүлэхүүнийг ялган бич. /1,5 оноо/
2. Цогцолборуудыг давтан холбосон гишүүнийг ялган бич. /1 оноо/
3. “э-, тэ-“ язгууртай заах төлөөний үгийн аль нь цогцолборыг, аль нь үгийг холбосон бэ? /1 оноо/
4. “бас, мөн” гэсэн үг ямар үүрэг, утгатай байна вэ? /1 оноо/
5. Онцолсон хэсгийн найруулгын хэв маягийг тодорхойл. /1.5 оноо/

Хоёрдугаар ажил. Өгүүлбэр (4 оноо)

1. Эхний цогцолбор дахь “туулаад ирснийг” гэдэг хэлзүйжсэн холбоо үг өгүүлбэр зүйн ямар холбоо харьцаанд байж, ямар үүрэг гүйцэтгэж байгааг тайлбарла. /2 оноо/
2. “няцаасан нь” гэдэг үгийн хэл зүйн хэлбэрийг ямар нөхцөлөөр солин найруулж болох вэ? /1 оноо/
3. “Энэ жил бас л Галданы цэрэг Цэцэн ханы аймгийг идэж буй” гэсэн өгүүлбэрийг нэрийн (өгүүлэгдэхүүний) ба үйлийн (өгүүлэхүүний) бүлгээр ялгаж бич. /1 оноо/

Гуравдугаар ажил. Үг зүй (4 оноо)

1. “няцаасан нь” гэдэг үгийг бүтцээр нь задалж бүтээвэр тус бүрийг нэрлэж бич. /2 оноо/
2. Дээрх эхэд орсон “Бээжинг идэх гэж”, “... дутаав гэж ...” гэсэн хам бүтцэд орсон “гэж” гэсэн хоёр үг тус бүрийн утга, үүргийг тодорхойл. /2 оноо/

Дөрөвдүгээр ажил. Үгийн сан, утга зүй (5 оноо)

1. Эхэд “идэх” гэсэн үг ямар утгаар орсныг ойролцоо үгээр нь тайлбарла. /1 оноо/
2. “Өдрийн сайныг үзэх” гэдэг хэлц үгийн утгыг тайлбарла. /1 оноо/
3. “ташингат” гэж ямар утгатай үг вэ? /1 оноо/
4. “эгэх” гэдэг үгийг ойролцоо утгаар нь тайлбарла. /1 оноо/
5. “дэлэм” гэж ямар хэмжээсийн нэр вэ? /1 оноо/

Тавдугаар ажил. Уран сайхны эх зохиох (5 оноо)

1. Дараах түлхүүр үгсээс оролцуулан уран дүрслэл бүхий 100 орчим үгтэй уран сайхны эх зохиож бичээрэй.

Түлхүүр үгс: Дов сондуул, жирэлзэх, голын тохой, сайр, дэнж, шуугиан, тойром, дурсамж, зүрх сэтгэл, үнэр, хөх дэгд

Зургаадугаар ажил. Уран зохиол (5 оноо)

1. Д.Батбаярын “Гэмшил” өгүүллэгийн гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг задлан шинжлээрэй. (5 оноо)

Долоодугаар ажил. Монгол бичиг (6 оноо)

1. “Гэмшил” эхийн сүүлийн 7 мөрийг “... Харин харьж явахдаа санагддаг юм” гэсэн хэсгийг монгол бичигт буулгана уу.

МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН ОЛИМПИАДЫН СЭДЭВ БАГШ

Нийт оноо 40

Ажиллах эх:

Ингээд л миний явдал гэдэг аль сайхан хүсэл эрмэлзэл, түүнтэй нийцэх эсэхийг огт хайхрахгүй цуварсаар, угалзан хээ тус бүрийг нь салган үзэхэд ямар ч учир ухагдахгүй мөртөө, хоорондоо бүх үзэгдэл нь шүтэн барилдаж, нэг нэгнээсээ маш чанд нарийн дэс дараатайгаар холбогдон гарч, хоорондоо тасрашгүй хэлхээтэй алаг эрээн угалз удтал сүлжсэн шиг үргэлжлэх бий гэж толгойгоо унжуулан бодож, мориныхоо жолоог сул тавиад, сэтгэлтэй нь ав адилхан гунихралт битүү ой модон дундуур явж байтал нь нэгэн цэрэг байгалийн сүр жавхланд сэтгэл нь хөдлөөд уртын дууг нам дуугаар аялан үүсгэсэнд бусад нь ая нийлүүлэн түрэлцсээр удалгүй олон хүний хоолой нийлж, нөмрөн ургасан ой хөвчийн дунд их л хол дуурсан дуулдвай.

А.Толстой “Мөнгөн ноён” зохиолын орчуулгын хэсгээс

ГҮЙЦЭТГЭХ ДААЛГАВАР:

Нэгдүгээр ажил. Эхийн даалгавар (7 оноо)

9. Цогцолборын үүдэл ба зорьсон санааг нэг нэг өгүүлбэрээр товч бичнэ үү. /2 оноо/
10. Цогцолбороос шинэ санаа бүхий жишээг татна уу. /1.5 оноо/
11. Цогцолборт эсрэгцсэн санааг хэрхэн илтгэж байна вэ? /2 оноо/
12. Төлөөний үг цогцолборт ямар үүрэгтэй орсныг товч тайлбарлана уу. /1.5 оноо/

Хоёрдугаар ажил. Өгүүлбэр (5 оноо)

9. Цогцолборын доторх “Гэ-“ холбох үгийн утга, үүргийг тайлбарла. /1 оноо/
10. Цогцолбороос баймж нэгжүүдийг ялгаж тайлбарла. /2 оноо/
11. Цогцолбороос санааг нарийвчлан тодруулсан хэсгийг олж учрыг тайлбарлана уу. /1 оноо/
12. “... нэгэн цэрэг байгалийн сүр жавхланд сэтгэл нь хөдлөөд, уртын дууг нам дуугаар аялан үүсгэсэнд...” гэсэн өгүүлбэрээс цөм өгүүлбэрүүдийг ялгаж бичнэ үү. /1 оноо/

Гуравдугаар ажил. Үгийн бүтэц, гарал (5 оноо)

7. Дараах нийлмэл үг тус бүрийн бүрэлдүүлэгчдийн хэлбэр, утгын харьцааг ажиглаад нэрлэлт бүтсэн аргыг нь тодорхойл. /2 оноо/
морь мал, морин шоргоолж, морин чих (ургамал)
8. Дараах үг тус бүрийг бүтцээр нь задлаад бүтээвэр тус бүрийг бүтцээр нь задлаад бүтээврийн нийлц дэх авианы хувьслын үзэгдлийг тайлбарла. /2 оноо/
эгнэ, сүрэлх, шахцалд, ирэгсэд
9. Дээрх эхэд орсон “нэг” гэдэг үгтэй түүхэн үүднээс төрөл үгийг эхээс олж бичнэ үү.

/1 оноо/

Дөрөвдүгээр ажил. Үгийн сан, утга судлал (5 оноо)

6. Цогцолборт байгаа тогтвортой нэгжүүдийг олж, тоочин бич.

Тавдугаар ажил. Уран сайхны эх зохион бичих (6 оноо)

3. “Дэндүү эрт би сониуч нүдээ аньсан
Дэлхий тэмтрэх ганцхан зам үлдсэн...” мөртөөс сэдэвлэн уран сайхны эх зохио.
Үгийн тоо 130-150

Зургаадугаар ажил. Уран зохиол (4 оноо)

5. Уран зохиол дахь “болзолт дүр” хэмээх ойлголтыг жишээ татан тайлбарлана уу.

Долоодугаар ажил. Монгол бичиг (8 оноо)

4. Дээрх эхийг монгол бичгээр хөрвүүлнэ үү. /5 оноо/

2024 ОНЫ МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН ОЛИМПИАДЫН СЭДЭВ СУРАЛЦАГЧ

Нийт оноо 40

Ажиллах эх:

Эдэлсэн эзэн гэртээ дурлаж, эдлэгдсэн морь нь ижилдээ дурлаж, унасан морины толгойг хазаарын хүчээр эргүүлэвч бүхэл бие нь адууны зүг явж, уурга ташуур хөшилдөөд унасан морь нь тэмцэлдээд, тал дээр ганц бие, адуун дотор ааш догширч, морины гуянд бүдүүн ташуур тас няс хийтэл тушааж, адууны дундаас халиун морийг унасан, урт уурга чирсэн нэг гавшгай хүн гарч, өмнө зүг чиглэн давхисаар нэг баялаг айлын гадаа буужээ.

/Ц. Дамдинсүрэн, Гологдсон хүүхэн, Уб., 1969, 421-рт/

ГҮЙЦЭТГЭХ ДААЛГАВАР:

Нэгдүгээр ажил. Эх задлал (5 оноо)

Дээрх цогцолбор дахь үйлдэгч эзнийг заасан үгсийг олж бич.

Хоёрдугаар ажил. Өгүүлбэр задлал (4 оноо)

- “хүн” гэсэн гишүүнд захирагдсан гишүүн өгүүлбэрийг олж бич. /1 оноо/
- “ганц бие”- өгүүлбэрт ямар гишүүн болох вэ? /1 оноо/
- Дээрх эхэд утгаараа эсрэгцсэн хэдэн өгүүлбэр байгааг олж бич. /1 оноо/

Гуравдугаар ажил. Үгийн сан, утга судлал (4 оноо)

- “Эдэлсэн эзэн гэртээ **дурлаж**, эдлэгдсэн морь нь ижилдээ **дурлаж**” - Онцолсон үгийн утгыг тайлбарла. /1 оноо/
- “...уурга ташуур **хөшилдөөд**”- Онцолсон үгийн утгыг тайлбарла. /1 оноо/
- “...**бүхэл бие нь** адууны зүг **явж**”- Онцолсон үгийн утгыг тайлбарла. /1 оноо/
- “морины гуянд бүдүүн **ташуур** тас няс хийтэл **тушааж**” - Онцолсон үгийн утгыг тайлбарла. /1 оноо/

Дөрөвдүгээр ажил. Бүтээвэр зүй (3 оноо)

- Дээрх эхэд орсон үгсийн дотроос харьяалах, заах, чиглэхийн тийн ялгалын нөхцөлийн тэг хувилбартай үг тус бүр нэгийг олж бичнэ үү. /2 оноо/
- “Эд-, дур-“ гэсэн нэр үндсэнд үйл үг бүтээх “-Л” дагаврыг залгаж бичээд тус бүрийн зөв бичих дүрмийг тайлбарлана уу. /1 оноо/

Тавдугаар ажил. Уран зохиол (10 оноо)

а. “Монголын нууц товчоон” (МНТ) зохиолд үзүүлсэн Алунгуа эхийн таван хүүхдийг нэрлэ. Тэдний хэн нь Чингис хааны дээд өвөг вэ? /2 оноо/ Түүнийг МНТ зохиолд хэрхэн дүрсэлсэн бэ? /2 оноо/ Энэ нь Чингисийн үйл хэрэгт ямар үлгэр загвар, уг сурвалж болж байна вэ? /2 оноо/

б. Б. Ринчен “Үдэш Невскийд” шүлгийг задлан шинжилж бичээрэй. (эсрэгцэл, ижилсэл) /4 оноо/

Б. Ринчен

Үдэш Невскийд

Трамвай тачигнан, машин пичигнэн,
Төмөр харчигнан хангинах чимээтэй,
Бензиний утаа үнэр дүүрсэн гудамж нь
Хээр тал нутагт минь ийм байдаггүй яа!
Үдшийн бүрийд харланхан сүндэрлэгч
Хад мэт боржин чулуун байшингийн ёроолд
Голын захын хөөс шиг, олны үймэлдэх нь
Хээр тал нутагт минь ийм байдаггүй яа!
Армений дарс, Арарат, Арарат! гэж
Албины гал шиг неоны хөх гал дөрөлзөн
Амьтны царай тэр гэрэлд аягүй муухай нь
Хээр тал нутаг минь ийм байдаггүй яа!
Эмэгтэйчүүдийн үс нь яасан ч шар юм бэ,
Хүний зүрх сугалж сорсон юм шиг,
Уруул хумс час улаанаар будсан нь
Хээр тал нутагт минь ийм байдаггүй яа!
Гудамжны аманд, киноны хаалган дээр
Хөлтэй олны дундаас хамгийн хайрт хүнээ
Мөч гаруй хүлээж хүүхэн хонгор зогсох нь
Хээр тал нутагт минь ийм л байдаг даа!
Интоор мэт уруулын завжинд гунил шингээд,
Зээрийн нүд шиг, охины тормогор нүд нь
Эрвээхэй шиг өөр зүг ниссэн түүнээ эрэх нь
Хээр тал нутагт минь ийм л байдаг даа!
Гэнэт завж нь татав татав инээмсэглээд,
Алдсан морио айлын адуунд олсон юм шиг
Хонгор нүд нь цолмон шиг гялалзах нь
Хээр тал нутагт минь ийм л байдаг даа!

/Ленинград, Европ буудал 64 тасалгаа, 1947.VII.28/

Зургаадугаар ажил. Зохион бичлэг (4 оноо)

“Ирж яваа цаг” гэсэн сэдвээр эргэцүүлэмж бичнэ үү. /Үгийн тоо- 100/ /Бичиж дуусаад зохион бичлэгийнхээ үгийн тоог бичээрэй./

Долоодугаар ажил. Монгол бичиг (10 оноо)

а. Дээрх ажиллах эхийг монгол бичигт хөрвүүлж бич. /10 оноо/

МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН ОЛИМПИАДЫН СЭДЭВ БАГШ

Нийт оноо 50

Ажиллах эх:

Ойр хавьдаа хэдэн өртөө газрын нутаг усны байдлыг үргэлж мэдэж байх, тухайн цаг үеийн байдлаар нэг малд нэг хоногт хэчнээн газрын өвс идэж цадахыг бодож, түүгээр тэр газар төчнөөн хонож болох юм байна гэж барагцаа бодоод, тэр хүртэл өөр бэлчээр эрж олох зэргээр дөрвөн цагийн өвс бэлчээрийг тохируулж хэрэглэх, бас ойр хавьд малын өвчин тахал, чоно нохой ээлтэй эсэхийг мэдэх, малын хүч тарга авхуулахад цаг цагт нь хэрэглэх өвс хужир бий үгүйг мэдэх, хавар цагийн бэлчээр нөөж, зун намар хаагуур нутаглахыг бодож олох, бас нэг ч эм малыг сувайруулахгүйг хичээх, мал төллөх үес нялх хурга хүйтэнд осгож үхэх вий гэж шөнө нойргүй сахих, өдөр ч хониндоо гарах үес хурганы ууттай явж, нялх хургыг уутандаа хийгээд үүрч юм уу, дүүрч гэртээ авчрах тул их ажилтай ажгуу.

/Б.Ринчен, Үүрийн туяа, УБ., 1971, 347-рм/

ГҮЙЦЭТГЭХ ДААЛГАВАР:

Нэгдүгээр ажил. Эх задлал (6 оноо)

- а. Уул цогцолбор хэдэн бүрэлдэхүүнтэй болох, түүнийг холбох буюу зааглах үгийг олж бич. /2 оноо/
- б. Уул цогцолбор дахь холбох хэрэглүүрүүдийг нэг бүрчлэн тоочиж бич. /3 оноо/
- в. Уул цогцолборын найруулгын хэв маягийг тодорхойлж бич. /1 оноо/

Хоёрдугаар ажил. Өгүүлбэр зүй (6 оноо)

- а. “түүгээр” гэсэн холбох үг ямар үүрэгтэй орсныг тайлбарлана уу. /1 оноо/
- б. Төгс өгүүлбэрийг ялгаж бич. /1.5 оноо/
- в. “... их ажилтай ажгуу” гэсэн өгүүлбэр нь аль аль гишүүн өгүүлбэрийг захирч байна вэ? /3.5 оноо/

Гуравдугаар ажил. Үгийн сан, утга судлал (6 оноо)

- а. Дээрх эхээс хоршоо үгийг олж тогтоо. /3 оноо/
- б. Мөн эхээс хэмт үгийг олж тогтоо. /3 оноо/

Дөрөвдүгээр ажил. Бүтээвэр зүй, үгийн гарал (6 оноо)

- а. Дараах нийлмэл хэлц тус бүрийн утга, бүтцийг ажиглаад үүссэн аргыг тодорхойл. /2 оноо/

үхрийн нүд (жимс), номын сан

- б. Дараах өгүүлбэрт нөхцөлдүүлэн холбох нөхцөлтэй үйл үг хэд байгааг олоод нөхцөл тус бүрийг нэрлэ. /2 оноо/

Мягмар алс холоос ирээд олон жил уулзаагүй дүүгээ харангуут хязгааргүй баярлаж дээ.

в. Эхэд буй “дүүрч” гэдэг үгийн түүхэн язгуурыг тогтоож, түүнтэй ижил язгууртай үг 4-ийг бичнэ үү. /2 оноо/

Тавдугаар ажил. Уран зохиол (10 оноо)

а. Бичил дүрслэл (detali) гэж юу вэ? / 2 оноо/

б. Дараах шүлгийн хэсгээс бичил дүрслэлийг олж тайлбарла. /3 оноо/

Эхийн сэтгэл

...Тэмээ тэмээн цагаан үүлийг
Тэндээ царцтал харлаа
Тэнгэрийн ягаан хаяаг
Цав суутал хүүгээ ширтлээ
Ижийдээ ирсэнгүй ээ..

П.Бадарч

в. Монголын нууц товчоон” зохиолын хэлц үгүүдээс гурвыг эш татан, утга, үүргийг тайлбарла. /3 оноо/

г. “Таяг” өгүүллэгээс далд утгыг илэрхийлсэн 2 жишээг олж тайлбарла./ 2 оноо

Таяг

Харандаагаар бичсэн энэ захидлыг нутгийн өвөө таяг захин илгээжээ. Тэр үед нь би төдий л яараагүй бөгөөд хоёр жилийн дараа хүрэн модон таяг хаа газраас дамналдуулан хүрч ирвэл өвөө өөд болчихсон байж билээ. Эдүгээ гучин насанд уул захидлыг дахин уншаад , “Тэр өвөө хөлөө янгинан өвдөж, өвдгөөр хатгуулан суун тусахдаа ганц намайг л дурсаж шүү дээ...тэрбээр хэвтрээсээ хүчлэн өндийж, хана эргэнэгээ түшсээр гадаа гарч, нар, тэнгэр, Жавхлант хайрхан, Улаан дэлийн хажуу дээр идшилж яваа хөгшин цагаан морио эцсийн удаа харахдаа надад захисан таягаа эрхгүй нэг дурсаа даа” гэж бодохунаа, ухаангүй багын явдлаа зүрх минь зэмлэн гасалж, нэгэнт орхин одсон тэр нэгэн хорвоог нэхэн халаглав.

Ээ, илээ гэж...нутгийн өвөө ганц ч хором бол босож ирээд тэр заяагүй таягийг шүүрэн авч, тархин дундуур минь нэг сайн татаад өгдөг ч болоосой...

Ж.Лхагва

Зургаадугаар ажил. Зохион бичлэг (6 оноо)

“Хүүхэд бол дүүргэж байдаг сав биш, дүрэлзэж байдаг бамбар мөн” гэсэн онч үгийг тайлбарлаж бичнэ үү. Үгийн тоо 200 үг. /Бичиж дуусаад зохион бичлэгийнхээ үгийн тоог бичээрэй./

Долоодугаар ажил. Монгол бичиг (10 оноо)

а. Дараах эхийг монгол бичгээр хөрвүүлж бич. /5 оноо/

Өгүүлбэрээс, араатан зэрлэгүүд адгуус малын, хүйтэн ус халуун галын, ярдаг нохой зальжин муурын, баян дээдэс бядуу харцын, янхан хүүхэн үнэнч гэргийн, тэнэг маанаг ухаант цэцний угийн дайсан байдаг буюу.

б. Кирилл бичигт буулгана уу. 5 / оноо/

